



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
SCHOOL OF ART AND SCIENCES
DEPARTMENT OF GEOGRAPHY

Geographical Issues

Газарзүйн Асуудлууд

Volume 26 (01)

ISSN: 2312-8534

2026

Ulaanbaatar

A Review Study on the Assessment of Transport Networks

Urantamir Gankhuyag^{1,2*}, Byambakhuu Gantumur¹, Battengel Vandansambuu¹, Altanbagana Myagmarsuren²

¹ Department of Geography, School of Art and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar 210646, Mongolia

² Division of Social and Economic Geography, Institute of Geography and Geoecology, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar 15170, Mongolia

* Corresponding author: urantamirg@gmail.com

Received: 2025.07.03

Revised: 2025.09.15

Accepted: 2025.09.16

Abstract

Regional cooperation, global trade, and the growing demand for transportation necessitate the development of efficient transport networks. This study aims to establish a comprehensive knowledge base on the evolution of transport networks, assess major axes and corridors, identify emerging trends, and highlight existing research gaps. To achieve this, a thematic taxonomy was developed based on objectives, topics, scope, keywords, methodologies, and similarities. Using the Web of Science (WoS) database, 937 publications related to transport networks and corridors were initially retrieved. Of these, 198 articles were selected and analyzed through three stages: assessing the accessibility of the papers, checking for overlap, and conducting content analysis. Recent studies on transport network and corridor assessments indicate that since 2021, the keywords 'Bayesian network', 'transport corridor', 'resilience assessment', and 'quality' have gained increasing prominence. The articles assessing transport networks and corridors can be categorized into five clusters according to the thematic taxonomy: (1) investment and benefit analysis, (2) performance assessment, (3) environmental, social, and economic impact analysis, (4) resilience and risk analysis, and (5) comparative assessment of alternatives. The methods most commonly employed in these assessments include multi-criteria analysis, data envelopment analysis, and time–cost–distance methods. While studies evaluating transportation alternatives have increasingly focused on efficiency, they have largely overlooked the issue of optimal spatial location. A comprehensive assessment that simultaneously addresses both efficiency and optimal spatial location could provide significant advantages.

Keywords: Transport networks, Transportation corridor, Spatial analysis, Network assessment, Spatial efficiency

Тээврийн сүлжээг үнэлэх судалгааны судлагдсан байдлын тойм

© Ганхуяг Урантамир^{1,2*}, Гантөмөр Бямбахүү¹, Вандансамбуу Батцэнгэл¹, Мягмарсүрэн Алтанбагана²

¹ Газарзүйн тэнхим, Шинжлэх Ухааны Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар 210646, Монгол Улс

² Нийгэм эдийн засгийн газарзүйн салбар, Газарзүй, геоэкологийн хүрээлэн, ШУА, Улаанбаатар 15170, Монгол Улс

*Харилцагч зохиогч: urantamir@gmail.com

Хүлээн авсан: 2025.07.03

Засварласан: 2025.09.15

Зөвшөөрөгдсөн: 2025.09.16

Хураангуй

Бүс нутгийн хамтын ажиллагаа, дэлхийн худалдаа, тээвэрлэлтийн өсөн нэмэгдэж хандлага нь үр ашигтай тээврийн сүлжээг хөгжүүлэх шаардлагыг бий болгож байна. Энэхүү судалгаа нь тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорын үнэлгээний судалгааны хувьслын талаар өргөн хүрээний мэдлэгийн бий болгох, улмаар шинээр гарч ирж буй чиг хандлагыг илрүүлэх, тэдгээрийн зорилго, сэдэв, цар хүрээ, түлхүүр үг, аргазүй, ижил төстэй байдалд тулгуурлан сэдэвчилсэн ангилал зүйг хийж, судалгааны цоорхойг илрүүлэхэд оршино. Уг судалгаанд Web of Science (WoS) мэдээллийн санг ашигласан бөгөөд тээврийн сүлжээ, коридортой холбоотой хайлт хийхэд 937 илэрцийг илрүүлж, улмаар өгүүллийн pdf байдлаар олдох боломж, давхцал, агуулгын шинжилгээ гэсэн 3 шатны шинжилгээ хийсний үндсэн дээр нийт 198 өгүүлэлд харьцуулсан дүн шинжилгээ хийсэн. Тээврийн сүлжээ, коридорын үнэлгээний талаарх сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаануудад авч үзвэл 2021 оноос хойш Байесын сүлжээ, тээврийн коридор, уян хатан байдлын үнэлгээ, чанар гэсэн түлхүүр үгс илүү хүчтэй ашиглагдах болсон байна. Тээврийн сүлжээ, коридорыг үнэлж буй нийтлэлүүдийг зорилго, сэдэв, цар хүрээ, түлхүүр үг, аргазүй, ижил төстэй байдалд тулгуурлан сэдэвчилсэн ангилал зүйг хийхэд хөрөнгө оруулалт ба үр ашгийн шинжилгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, уян хатан байдал ба эрсдэлийн шинжилгээ, хувилбаруудын харьцуулсан үнэлгээ гэсэн 5 кластерт хамруулж үзэх боломжтой байна. Тээврийн сүлжээ, коридорын үнэлгээнд гол төлөв олон шалгуурын дүн шинжилгээ, өгөгдлийн бүрхүүлийн шинжилгээ, цаг хугацаа-зардал-зайн аргыг ашиглаж байна. Тээврийн хувилбаруудыг үнэлж сонголт хийсэн судалгаануудад үр ашгийн асуудалд илүүтэй төвлөрч байгаа ба орон зайн оновчтой байршилыг бага харгалзсан бөгөөд орон зайн оновчтой байршил, үр ашгийн асуудлыг цогцоор үнэлэх нь илүү давуу талыг бий болгох боломжтой байна.

Түлхүүр үгс: Тээврийн сүлжээ, Тээврийн коридор, Орон зайн дүн шинжилгээ, Сүлжээний үнэлгээ, Орон зайн үр ашиг

©Зохиогчийн оруулсан хувь нэмэр: **Г.Урантамир:** Онолын үндэслэл, аргазүй боловсруулалт, өгөгдөл боловсруулалт, үндсэн бичвэр, өгөгдөл цуглуулалт, боловсруулалт **Г.Бямбахүү:** Судалгааны мэдээ, материал бүрдүүлэлт, боловсруулалт, үр дүнгийн хяналт **В.Батцэнгэл, М.Алтанбагана:** Үр дүнгийн хяналт.

Оршил

Даяаршил, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжиж, улс хоорондын худалдаа нэмэгдэж байгаа өнөө үед зам, тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн хөгжүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Тээврийн сүлжээ нь зангилаа (төв) зам буюу зангилааны хоорондох холбоосоор илэрхийлэгдсэн холболтууд бөгөөд холбоос нь авто зам, төмөр зам гэх мэт бодит зам, тээврийн коридорууд, эсвэл агаарын болон далайн коридор байж болно (Rodrigue et al., 2013). Сүлжээг бий болгох нь тухайн бүс нутагт нэвтрэх, хөдөлгөөнийг хангах, тодорхой худалдааны коридор эсвэл технологийн хөгжлийг бэхжүүлэх, тодорхой горим, сүлжээг илүү давуу талтай болгох зэрэг стратегийн үр дүнд бий болдог (Jean-Paul Rodrigue, 2013).

Тээврийн тэнхлэгийн талаар ойлголтуудыг нэгтгэн илэрхийлбэл нийгэм, эдийн засгийн гол төвүүд, нутаг дэвсгэрийг гадаад орнуудын үндсэн тэнхлэгүүдтэй холбож, худалдаа, зорчигч, ачаа тээврийн эргэлт, мэдээллийн урсгал, солилцоог нэмэгдүүлэх эдийн засаг, дэд бүтцийн шугаман бүс гэж ойлгох боломжтой (Алтанбагана, 2022).

"Тээврийн коридор" гэсэн ойлголтод нарийн тодорхойлолт байхгүй боловч энэ нь физик болон функциональ хэмжигдэхүүнтэй байх ба физик бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд коридор нь эдийн засгийн үйл ажиллагааны төвүүдийг холбосон нэг буюу хэд хэдэн чиглэлийг агуулдаг (Arnold, 2005). Тээврийн төлөвлөлтийн асуудал нь эдийн засаг, нийгэм, байгаль орчинд хамгийн их ашиг тустай байх үүднээс авто зам, төмөр зам, дугуйн зам, явган хүний зам зэрэг биет дэд бүтцийг зохион бүтээх, байршуулах тухай ойлголт юм (O'Flaherty, 1997; Parkin, 2018).

Дэлхийн бүс нутгууд тээврийн тэнхлэг, коридорыг хөгжүүлэх томоохон санаачилгууд хөгжиж байна (Алтанбагана, 2022). Тухайлбал Евроазид "Бүс ба Зам" санаачилга, Транссибирийн тээврийн коридор, Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн интеграци зэрэг дэлхийн дэд бүтцийн хөгжлийн стратегийн чиглэлээр янз бүрийн санаачилга, хамтын ажиллагаа батлагдаж байна (Choi, Young, 2007). Тээврийн тусламжтай улс орон, бүс нутаг, аймаг сумдын хооронд болон гадаад орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа, бүтээгдэхүүн солилцоо явагдаж байдаг (Авхинсүх, 2009). Далайд гарцгүй орнуудын хувьд дамжин өнгөрөх тээврийг нөхцөлийг хангах, үр ашигтай тээврийн системийг хөгжүүлэхэд бүс хамтын ажиллагаа зайлшгүй чухал юм (Regmi, Hanaoka, 2012). Шинэ дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэхийн тулд эхлээд бүх боломжит хувилбаруудыг тодорхойлох, хоёрдугаарт, хувилбаруудыг эдийн засгийн үнэлгээ өгөх шаардлагатай (Gramlich, 1994).

Тээврийн дэд бүтэц нь байгаль орчинд ихээхэн нөлөө үзүүлдэг урт хугацааны, маш өндөр өртөгтэй хөрөнгө оруулалт юм. Юу, хаана, хэзээ хөрөнгө оруулалт хийх вэ гэдэг асуудлыг зах зээлийн хүчин дангаараа шийдэж чадахгүй. Тээврийн сүлжээг төлөвлөх шаардлагатай. Технологийн дэвшил, зохицуулалттай үйлдвэрүүдийн туршлага, эдийн засгийн онолын сүүлийн үеийн хөгжил, төсвийн хатуу хязгаарлалт зэрэг нь засгийн газруудыг тээврийн дэд бүтцийг төлөвлөх, үнэлэх аргачлалыг эргэн харах нөхцөлийг шаардах болсон (De Rus, Socorro, 2017).

Тээврийн сүлжээ, тээврийн асуудлуудтай холбоотой судлагдсан байдлын шинжилгээ хийсэн өгүүлэл харьцангуй цөөн байна. Тухайлбал Ansari et al. (2018) нар логистик ба тээврийн системийн сүүлийн үеийн дэвшил, одоогийн судалгааны цоорхойг тодорхойлох зорилгоор тасралтгүй ойролцоо тооцоолол (CA) загваруудыг боловсруулсан 1996-2016 оны хооронд хийгдсэн судалгаануудад судлагдсан байдлын шинжилгээ хийж, судалгааны цоорхой, асуудлуудыг томьёолсон. Marchetti, Wanke, (2019) нар төмөр замын тээврийн үр ашгийг тодорхойлсон 2000-2016 оны хооронд хийгдсэн төмөр замын үр ашгийн талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, параметрийн болон параметрийн бус загваруудын тооцоолол, мета-анализыг ашиглан түүврийн дундаж үр ашгийн өөрчлөлтөд нөлөөлж болох гол талуудыг олж тогтоожээ. Wang et al. (2019) нар тээврийн системийг гүнзгий сургалтын технологийн талаарх

судлагдсан байдлыг тойм судалгааг явуулж, улмаар тээврийн олон хэрэглээнд хэрхэн ашигласан талаар тодорхой дүр зургийг гаргасан. Karam et al. (2021); Van Eldijk et al. (2022) нар тээврийн сүлжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаар судлагдсан байдлын судалгаа хийж, тулгарч буй саад бэрхшээлүүд, тэдгээрийн үр нөлөөг үнэлэх бодит аргуудыг санал болгожээ. Alhjouj et al. (2022) нар тогтвортой тээврийн дэд бүтцийн талаар 1997-2021 оны хооронд хийгдсэн 683 өгүүлэлд судлагдсан байдлын шинжилгээ хийж, тогтвортой зам дахь хамгийн сүүлийн үеийн байдлыг нэгтгэн дүгнэжээ. Sahin (2023) нийтийн тээврээр зорчих шийдвэр гаргалтын талаар сүүлийн 18 жилийн хугацаанд хэвлэгдсэн өгүүлүүдэд судлагдсан байдлын шинжилгээ хийсэн. Borchers et al. (2024); Mumm et al. (2025); Johari et al. (2021) нар хотын хөдөлгөөн, хотын сүлжээний макроскоп загварчлал, хотын газар ашиглалт, тээврийн харилцан үйлчлэл, сүлжээний талаар судлагдсан байдлын тойм шинжилгээг хийсэн. Giuffrida et al. (2019) нар тээврийн судалгаанд сайн дурын газарзүйн мэдээлэл болон олон нийтийн оролцоотой GIS-ийн хэрэглээний талбаруудын талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, олон шалгуурт шийдвэрийн дүн шинжилгээ хийх нь хамгийн ашигтай арга болохыг тодорхойлсон.

Эдгээр судлагдсан байдлын тоймуудад тээврийн систем, түүнд гүнзгий сургалтын аргыг ашиглах, төмөр замын тээврийн үр ашгийг тодорхойлох, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, хөгжлийн асуудал, нийтийн тээврийн зорчих шийдвэр гаргалт, хотын замын хөдөлгөөн, сүлжээний макроскоп загварчлал, газар ашиглалт, тээврийн судалгаанд ГМС-ийг ашиглах асуудлыг авч үзжээ. Гэвч тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорын үр ашигтай сүлжээг бий болгох, орон зайн хувьд оновчтой байршлыг үнэлэх судалгаанд шууд ашиглах, холбогдох арга аргачлалыг судалсан судлагдсан байдлын тойм судалгаа хомс байна. Тиймээс тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорыг орон зайн хувьд оновчтой байршлыг тодорхойлох, үр ашигтай сүлжээ бий болгох, үнэлэх асуудлыг системтэй судлах, өмнө хийгдсэн судалгаануудын цоорхойг илрүүлэх, орчин үеийн шаардлагад нийцсэн аргагүйн болон хүчин зүйлсийн тодорхойлох хэрэгцээ үүсэж байна.

Энэхүү тойм өгүүлэл нь ялангуяа тээврийн сүлжээ, тээврийн тэнхлэг, тээврийн коридорыг үнэлэхтэй холбоотой асуудлуудыг судалсан судалгаануудаас шаардлагатай арга аргачлал, холбогдох хүчин зүйлсийг тодорхойлсон.

Судлагдсан байдлын шинжилгээ хийх олон аргыг судлаачид боловсруулжээ. Тухайлбал системчилсэн дүн шинжилгээ (Alvarez et al., 2021; Matsa et al., 2024; Johnson et al., 2022), реалист судлагдсан байдлын тойм арга (Baykasoglu et al., 2019), библиометрийн шинжилгээний арга (Shi et al., 2020), шинжлэх ухааны тоон судалгааны дүн шинжилгээ (Gandhi et al., 2022), эшлэл, сүлжээ, хамтарсан үгийн шинжилгээ, холимог аргын тойм (Gu, Liu, 2025) зэрэг аргууд байна (Зураг 1).




Зураг 1. Судлагдсан байдлын шинжилгээ хийх аргачлал

Уг судалгаа нь өмнө хийгдсэн судалгаануудыг гол болгож байгаа тул системчилсэн дүн шинжилгээ хийх арга зүй хэрэглэх нь илүү тохиромжтой байна. Энэхүү арга нь одоо байгаа баримт бичгүүдийг хайж олох, харьцуулах, үнэлэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, нотлох баримтыг үнэлэх боломжийг олгодог бөгөөд ингэснээр тухайн судалгааны хүрээнд юуг нь судалсан, юу нь судлагдаагүй талаар дүгнэлт гаргах боломжтой (Alvarez et al., 2021) болно.

Тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорын үнэлэх судалгааны хувьслын талаар өргөн хүрээний тойм хийх, шинээр гарч ирж буй чиг хандлага, сэдэвчилсэн ангилал зүй, хүчин зүйлийн цоорхойг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны материал, аргазүй

Ихэнх зохиогчид холбогдох судалгааг олохын тулд системчилсэн судлагдсан байдлын шинжилгээнд хамрах хүрээ, чанарт тулгуурлан google scholar, WoS гэх мэт олон мэдээллийн санг өргөн (Li Xiao, 2017) ашигладаг. Тийм учраас энэхүү судалгаанд WoS мэдээллийн санг ашигласан. Системчилсэн судлагдсан байдлын тоймыг боловсруулахдаа PRISMA удирдамж (Johnson, Matthews et al. 2022)-ыг (Зураг 2) ашигласан.



Зураг 2. Системчилсэн судлагдсан байдлын тойм судалгаа явуулах PRISMA схем.

WoS мэдээллийн сан нь 2017 оноос үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд бид тээврийн сүлжээний үнэлгээ, тээврийн коридорын үнэлгээ, тээврийн сүлжээний судлагдсан байдал гэсэн 3 түлхүүр үгээр 2017 оноос 2025 оны 3 сар хүртэл хэвлэгдсэн нийтлэлүүдэд хайлт хийж библиометрийн өгөгдлийг бүртгэсэн.

Гарчиг нь нарийн төвөгтэй шинж чанартай тул тавьсан зорилгодоо хүрэхийн тулд янз бүрийн төрлийн түлхүүр үгсийг ашигласан (Matsa et al., 2024). Энэхүү хайлтаар нийтлэлийн гарчиг, хураангуй эсвэл түлхүүр үгийн аль алинд нь сонгогдсон 3 түлхүүр үгтэй таарч тохирсон

өгүүлүүдийг илрүүлсэн. Урьдчилсан хайлтаар 937 өгүүлэл олдсон бөгөөд хэд хэдэн хасах шалгуурыг ашиглан шүүлтүүр хийсэн. Үүнд:


Нэгдүгээрт дээрх хайлтын илэрцээс PDF байдлаар татаж авах боломжтой өгүүллийг ялгасан. Үүний үр дүнд нийт 380 өгүүлэл хасагдсан. Хоёрдугаарт өгүүллийн давхцалд дүн шинжилгээ хийхэд судлагдсан байдлын харьцуулсан судалгааны өгүүллээс 13, тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорыг үнэлгээ хийсэн судалгааны өгүүллээс 30 өгүүлэл хасагдсан. Түлхүүр үгийн хувьд уялдсан ч өөр өөр сэдвээс гарсан нийтлэлүүдийг хасах (Meyer, 2020) шаардлагатай. Гуравдугаарт өгүүллийн судалсан асуудалд хяналт хийхэд нийт 327 өгүүлэл хасагдсан. Төгсгөлд нь 198 өгүүллийг Endnote программ дээр хадгалж, судлагдсан байдлын шинжилгээнд хамруулсан.

Бид тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорыг үнэлэх талаар хийгдсэн судалгаа, тэдгээрийн чиг хандлагыг тоймлохын тулд эхлээд түлхүүр үгсийн давтамж, цаг хугацааны үечлэлд тулгуурлан харьцуулсан шинжилгээ хийсэн. Үүний дараа хавсарсан байдлын шинжилгээ хийх замаар кластеруудыг үүсгэсэн. Энэхүү судалгаанд кластерын зураглал хийхэд Van Eck (2010)-ын боловсруулсан VOSviewer шинжлэх ухааны тоон судалгааны дүн шинжилгээ хийх программ хангамжийг ашигласан. VOSviewer нь эх сурвалж, улс орон, байгууллага, зохиогчид, баримт бичиг, түлхүүр үгсийн интерактив номзүйн сүлжээг хамтран зохиогч, эсвэл эшлэлийн холболт дээр үндэслэн үүсгэх хэрэгсэл юм (Gandhi et al., 2022). Үүсгэсэн кластер бүрээр тээврийн сүлжээ, тэнхлэг, коридорыг үнэлэх аргачлалуудад харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Сэтгүүлийн хуваарилалт ба эшлэлийн дүн шинжилгээ: Судалгаатай холбоотой өгүүллийн тоо 2017 оноос хойш нэмэгдэж байгаа хэдий боловч тээврийн сүлжээг орон зайн талаас бус үр ашгийн талаас үнэлэх байдал нь нэмэгдсэн байна. Боломжит шалтгаан нь бүс нутгийг дамнасан томоохон тээврийн коридорууд хөгжих болсон, нөгөөтээгүүр эдгээрийн коридоруудыг хөгжүүлэхэд үр ашгийн тооцооллын зайлшгүй хийх шаардлага бий болсонтой холбоотой байж болох юм.


Нийт 198 өгүүлэл нь 89 өөр сэтгүүлд харьяалагдах бөгөөд 74 сэтгүүл нь жилд нэгээс хоёр өгүүлэл гаргаж байгаа бол шилдэг 9 сэтгүүл нийт өгүүллийн 44 орчим хувийг нийтэлж байна. Зураг 2-т тэргүүлэх сэтгүүлүүдийн оруулсан өгүүлүүдийг харуулав. Өгүүллийн тоогоор, Европын тээврийн судалгааны тойм (22 нийтлэл, 11.3%) тэргүүлж, Тээврийн судалгааны бичиглэл сэтгүүл (11, 5.6%), Тээврийн судалгааны С хэсэг: Шинээр гарч буй технологи (10, 5.1%), Тогтвортой байдал (9, 4.6%) ИЕТ ухаалаг тээврийн систем (8, 4.1%), Дэвшилтэт тээвэр, Тээврийн газарзүйн сэтгүүл, Тээврийн судалгааны Е хэсэг: Логистик тээврийн тойм сэтгүүл (7, 3.5%) удаалж байна. Мөн өгүүлэлд ногдох дундаж эшлэл нь сэтгүүлийн өгүүллийн нөлөөг тодорхойлох чухал үзүүлэлт юм. Хамгийн олон өгүүлэл нийтэлсэн сэтгүүл нь хамгийн нөлөө бүхий сэтгүүл байх албагүй бөгөөд нэг өгүүлэлд ногдох эшлэлийн тоо нь өндөр сэтгүүл нь илүү ач холбогдолтой байна. Тээврийн судалгааны С хэсэг: Шинээр гарч буй технологи сэтгүүлд холбогдох арван өгүүлэл нийтлэгдсэн бөгөөд нэг өгүүлэлд дунджаар 250 гаруй эшлэл авч (Зураг 3) байна.



Зураг 3. Хамгийн олон өгүүлэл хэвлэгдсэн шилдэг 9 сэтгүүл

Түлхүүр үгсийн хавсарсан байдлын шинжилгээ: Агуулгын дүн шинжилгээ нь түлхүүр үгс болон бусад тархалтын давтамж дээр үндэслэн одоогийн халуун сэдвүүдийг тодорхойлох зорилготой бөгөөд одоо байгаа судалгаануудын дунд эшлэлийн сүлжээний дүн шинжилгээ хийсний дараа үргэлж ашигладаг арга юм (Van Meeteren et al., 2016; Leung et al., 2018; Wu et al., 2019). Нөгөөтгээгүүр түлхүүр үгст шинжилгээ хийснээр агуулгын хувьд өгүүллийг ангилах боломжийг олгодог (Gandhi et al., 2022).


Судалгааны ашиглаж буй түлхүүр үгнүүдийг давтамж, цаг хугацааны үечлэлээр харьцуулсан дүн шинжилгээ хийхэд 2017-2020 оны хооронд дизайн, тээврийн коридор, тээврийн сүлжээ, гүйцэтгэл, замын хөдөлгөөний хяналт, цахилгаан тээвэр, 2021-2023 оны хооронд эрсдэлийн үнэлгээ, тээврийн дэд бүтэц, эрчим хүчний үр ашиг, систем, загвар, далайн тээвэр, бүс, тээврийн коридор гэсэн үгс олон давтамжтай байсан бол 2023 оноос хойш уян хатан байдлын үнэлгээ, эмзэг байдлын үнэлгээ, сүлжээ, чанар гэсэн үгс олон давтамжтай ашиглагдах болсон (Зураг 4) байна.



Зураг 4. Хамгийн олон давтагдсан эшлэл бүхий шилдэг 20 түлхүүр үгс

Түлхүүр үгсийн шинжлэх ухааны зураглал дээр үндэслэн сэдэвчилсэн ангилал зүйг боловсруулах боломжтой бөгөөд 2017-2025 оны хооронд цуглуулсан 198 өгүүлийг түлхүүр үгс, судалгааны цар хүрээ (Зураг 5), ижил шинж чанартай сэдвүүдийг өөр өөр салбар, дэд салбаруудад нэгтгэж, ангилал зүйг нэгдмэл, ойлгоход хялбар үүднээс ерөнхийлөхөд дараах таван асуудалд хувааж үзэх боломжтой байна. Үүнд:

- (I) Тээврийн сүлжээ, коридорын хөрөнгө оруулалт ба үр ашгийн шинжилгээ
- (II) Тээврийн сүлжээ, коридорын гүйцэтгэлийн үнэлгээ
- (III) Тээврийн сүлжээ, коридорын байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ
- (IV) Тээврийн сүлжээ, коридорын уян хатан байдал ба эрсдэлийн шинжилгээ
- (V) Тээврийн сүлжээ, коридорын хувилбаруудын харьцуулсан үнэлгээ



Зураг 5. Түлхүүр үгсийн давтагдал, уялдаа холбоо

Судалгааны асуудлын харьцуулсан шинжилгээ:

(I) Тээврийн сүлжээ, коридорын хөрөнгө оруулалт ба үр ашгийн шинжилгээ: Tawfik, Limbourg (2018) Европын тогтвортой тээврийн системийг бий болгохын тулд интермодалийн тээвэртэй холбоотой үнийн асуудлыг судалсан. Marchetti, Wanke (2019) төмөр замын тээврийн үр ашгийг тодорхойлохтой холбоотой судлагдсан байдлын шинжилгээ хийж, параметрийн болон параметрийн бус загваруудын тооцоолол, мета-анализыг ашиглан түүврийн дундаж үр ашгийн өөрчлөлтөд нөлөөлж болох гол талуудыг олж тогтоожээ. Almotahari, Yazici, (2020) тээврийн сүлжээний топологи, түгжрэлийн түвшний талаар судлагдсан байдлын судалгаа хийж, тээврийн сүлжээний үр ашгийн хэмжигдэхүүн, холбоосны урсгал нь сүлжээний тодорхой шинж чанаруудыг төлөөлөх боломжтойг тодорхойлжээ.

Mitsubishi (2005) Тээврийн коридорын үр ашгийг дээшлүүлэхэд тээврийн мэдээллийн систем, боомтын бүтээмж, худалдаа, тээврийг хөнгөвчлөх, тээврийн дэд бүтэц, олон төрлийн тээврийн холболт, засгийн газар хоорондын хамтын ажиллагаа зэрэг нь чухал ач холбогдолтой болохыг тодорхойлжээ. De Rus, Socorro (2017) тээврийн дэд бүтэцэд оруулсан хөрөнгө оруулалтыг судалж, нийтлэг ойлголтуудыг боловсруулж, дэлхийн тээврийн дэд бүтцийн төлөвлөлт, үнэлгээ, санхүүжилтийг илүү үр ашигтайгаар хэрэгжүүлэх шинэлэг арга зам, бүс нутгийн хөгжил оруулж хувь нэмрийг тодорхойлсон. Zhou et al. (2019) агаарын тээврийн сүлжээний үр ашгийг хэмжих шалгууруудыг санал болгож, дотоодын найман агаарын тээврийн сүлжээг үнэлсэн. Abdulsattar et al. (2020) хөдөлгөөнт байдлын үр ашиг нь холбосон тээврийн хэрэгслийн зах зээлд нэвтрэх түвшин болон хөдөлгөөний урсгалын хурднаас ихээхэн хамаарч байгааг тодорхойлсон.

Тээврийн сүлжээ, коридорын үр ашгийг хэмжихдээ гол төлөв өгөгдлийн бүрхүүлийн шинжилгээг (Jitsuzumi, 2010; Oum, 2013; Doomernik, 2015; Kutlar et al., 2013; Mallikarjun et al., 2014; Loureiro et al., 2025) ашигласан.

Тээврийн дэд бүтцийн төслийг төлөвлөх, санхүү, үр ашгийн талаарх өмнө хийгдсэн судалгаануудаас үзэхэд тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг оновчтой болгох, үр ашгийг дээшлүүлэхэд тээврийн мэдээллийн систем, боомтын бүтээмж, худалдаа, тээврийг хөнгөвчлөх,

тээврийн дэд бүтэц, олон төрлийн тээврийн холболт, засгийн газар хоорондын хамтын ажиллагаа зэрэг нь чухал ач холбогдолтой байна.

(II) *Тээврийн сүлжээ, коридорын гүйцэтгэлийн үнэлгээ*: Zuniga-Garcia et al. (2018) олон талт түвшний үйлчилгээний (MMLOS) аргачлалыг ашиглан Техас мужийн Остин дахь артерийн коридорын мультимодаль гүйцэтгэлийг үнэлэх найман аргыг харьцуулж, HCM болон TCQSM аргачлалыг ашиглах нь хамгийн үр дүнтэй болохыг тодорхойлсон. Dimitriou, Sartzetaki (2020) Хар тэнгисээс Зүүн өмнөд Газар дундын тэнгис хүртэлх ачаа тээврийн шинэ коридор байгуулах тээврийн төслийн амьдралын мөчлөгийн туршид эдийн засгийн тогтолцоонд оруулах нийт хувь нэмэр, гүйцэтгэлийн гол тоон үзүүлэлтийг тодорхойлсон. Walker et al. (2022) түүхэн гео бүтцэд тулгуурлан Их Британийн тээврийн дэд бүтцийн гүйцэтгэлд цаг агаарын нөлөөллийг судалжээ. Ivina, Ma (2024) Шведийн төмөр замын сүлжээг хамарсан найман гол шугамын байршлыг 12 шалгуур үзүүлэлтийг ашиглан дүн шинжилгээ хийж, ажлын гүйцэтгэлийн эцсийн хугацаа дөхөх тусам төлөвлөгөөний тогтвортой байдал буурч байгааг тогтоосон. Initiative (2013) GTI тээврийн коридорыг тодорхойлох цогц судалгааг хийж, тээврийн коридорын худалдаа, тээврийн өнөөгийн гүйцэтгэлийн байдал, тэдгээртэй холбоотой хязгаарлалтууд, илүү сайн ажиллуулах бодлогын зарим чиглэлийг тодорхойлсон.

Тээврийн коридорын гүйцэтгэлийг үнэлэхдээ гүйцэтгэлийн гол шалгуур болон хүчин зүйлийн кластерын шинжилгээ (Serra, Fancello 2020), өгөгдлийн бүрхүүлийн шинжилгээний (DEA) арга (Bhanot, Singh 2014; George, Rangaraj 2008)-ыг ашигласан.

(III) *Тээврийн сүлжээ, коридорын байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ*: Milewicz et al. (2023); Theilig et al. (2024); Wang et al. (2024); Garcia-Onetti et al. (2021); Némethy et al. (2022) нар тээврийн сүлжээ, коридорын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг судалж, дуу чимээ, утааны бохирдлыг бууруулах, байгалийн амьдрах орчин, ойн амьтадын популяцид тээврийн нөлөөллийг хязгаарлах, усан зам, төмөр замын тээврийг тогтвортой хослуулах, ногоон дэд бүтцийг хөгжүүлэх, усны нөөцийг нөхөх шаардлагатай байгааг тогтоожээ. Theilig et al. (2024) байгаль орчинд ээлтэй барилгын эд анги, барилга байгууламжийн талаар системчилсэн судлагдсан байдлын судалгаа хийсэн. Wang et al. (2024) “Бүс ба Зам” санаачилгын байгаль орчин үзүүлэх нөлөөллийн талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, эдийн засгийн коридор нь аялал жуулчлалын хөгжил, иргэдийн сайн сайхан байдал, байгаль орчны аюулгүй байдалд нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тогтоосон.

Тээврийн сүлжээ, коридорын нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар олон судалгаа хийгджээ. Тухайлбал Li, Neal (2024) хотын төвлөрөл, хотын тээврийн сүлжээг харьцуулсан. Monsivais et al. (2018) тээврийн бодлого, төлөвлөлтийг хүн амын таргалалттай уялдуулан шинжилж, идэвхтэй алхах, дугуй унах байдлаар аялах болон хүнсний орчин чухал нөлөөтэйг тодорхойлсон. Wild (2024) хотын агаарын тээврийн олон талт байдлын талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, агаарын хөдөлгөөнийг одоо байгаа тээврийн системд амжилттай нэгтгэхийн тулд тэгш хүртээмж, тогтвортой үйл ажиллагаа, олон нийтийн оролцооны талаар нэмэлт судалгаа хийх шаардлагатайг тогтоосон. Schilling et al. (2019) Европ дахь гоц халдварт өвчтэй өвчтөнүүдийн тээврийн хүчин чадалтай холбон судалж, Европын 16 орны 48 тусгаарлах байгууламжийг асуулгын аргаар үнэлсэн.

Тээврийн сүлжээ, коридорын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар цөөнгүй судалгаа хийгджээ. Тухайлбал Muzamwese et al. (2024) аж үйлдвэрийн кластер дахь сүлжээнүүдийн нөлөөллийг харьцуулсан. Zubedi et al. (2022) Бүс ба Зам санаачилгын эдийн засгийн нөлөөллийг судалж, нүүрстөрөгчийн ялгарал болон эрчим хүчний хэрэглээ, эдийн засгийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал нөлөөтэйг онцолсон. Kos et al. (2018) Пан-Европын коридор Vc-ын цаашдын хөгжил, түүний боомтод үзүүлэх нөлөөллийг судалж, улс хоорондын маргаан, геополитикийн харилцааны асуудал чухал нөлөөтэйг тодорхойлсон. Sakalys et al. (2019)

үйлчилгээний чанар (тээврийн цаг, үйлчилгээ болон хүлээлгийн хугацаа, харьцах хугацаа, ажлын цаг, найдвартай байдал, уян хатан байдал) нь тээврийн коридорын синхромодализмд нөлөөлдөг хамгийн чухал үзүүлэлт (шалгуур) болохыг тогтоожээ.

Тээврийн сүлжээ, коридорын нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үзүүлэх цогц нөлөөллийн талаар цөөнгүй судалгаа хийгджээ. Тухайлбал Povoroznyuk et al. (2023); Lim et al. (2017) нар судлагдсан байдлын шинжилгээнд тулгуурлан төмөр замын коридоруудын нийгэм, хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөллийг харьцуулсан. Ahmed et al. (2023) тээврийн коридорын төслийн тогтвортой байдалд дэд бүтцийн муу нөхцөл, хотын түүхэн дүр төрх, нийтийн тээврийн давуу тал, төсвийн ил тод байдлын дутагдал, сонгууль зэрэг хөндлөнгийн нөхцөл байдал нь төслийн тогтвортой байдалд нөлөөлж байгааг тогтоосон. Mansourianfar, Haghshenas (2018) хотын тээврийн систем дэх дэд бүтцийн төслүүдийн тогтвортой байдлыг гурван хэмжигдэхүүнээр (байгаль орчин, нийгэм, эдийн засаг) 10 тоон үзүүлэлтээр үнэлсэн. Liu et al. (2021) бүс нутгийн болон тээврийн тогтвортой байдлын илтгэсэн хоёр багц 18 үзүүлэлтийг ашиглан хотын бүсийг үнэлсэн. Cheng, Chen, (2022) өндөр хурдны галт тэрэгний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судлагдсан байдлын шинжилгээ хийж, нийгэм, эдийн засагт хүртээмжийн өөрчлөлт, тээврийн бусад хэлбэрт үзүүлэх нөлөө, байгаль орчин, аялал жуулчлал, орон сууц, газар ашиглалт, хөдөлмөрийн зах зээл ба үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт зэрэг чухал ач холбогдолтойг тодорхойлсон.

Тээврийн сүлжээ, коридорын байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаанд олон шалгуурт шийдвэр гаргалтын арга (Theilig et al., 2024; Mansourianfar, Haghshenas 2018), олон шалгуурын шинжилгээний арга (MCA) (Liu et al., 2021), асуулга судалгааны арга (Schilling et al., 2019)-ыг ашиглажээ.

(IV) Тээврийн сүлжээ, коридорын эрсдэлийн шинжилгээ: Gonçalves, Ribeiro (2020; Wang et al. (2024) нар хотын болон хот хоорондын тээврийн системийн уян хатан байдлын онолын судалгааг хийж, улмаар үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргазүйн харьцуулсан шинжилгээг хийсэн. Van Eldijk et al. (2022) сүүлийн 60 жилийн тээврийн сүлжээний хөгжилд нөлөөлж буй саад бэрхшээлийн талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, улмаар саад бэрхшээлийн үр нөлөөг үнэлэх бодит аргуудыг санал болгожээ. Karam et al. (2021) тээврийн сүлжээг хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, улмаар бизнесийн загвар, мэдээлэл солилцох, хүний хүчин зүйл, хамтын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх систем (CDSSs) болон зах зээл гэсэн таван ангиллын хүрээнд 31 төрлийн саад тогторыг илрүүлсэн. Hertel et al. (2023) төмөр замын сүлжээнд холбоход тулгарч буй бэрхшээлийг судалж, хөдөө орон нутагт төмөр замын системийг дахин хөгжүүлэхэд ашиглах боломжтой тээврийн хэрэгслийн шинэ үзэл баримтлалыг бий болгох шаардлагатайг тодорхойлсон. Aparicio et al. (2022); Sohounou et al. (2020) нар олон төрлийн тээврийн сүлжээний барилгын чанарыг үнэлэх аргуудыг судалж, мультимодаль тээврийн сүлжээний тохирох олон давхаргат, хөдөлгөөнд мэдрэмтгий загварчлал, GREREC загвар, сүлжээний дүн шинжилгээ нь сүлжээний барилгын чанарыг тооцоолох боломжтойг тодорхойлсон.

Colonna et al. (2018) замын аюулгүй байдлын шинжилгээ хийх чанарын болон тоон хоёр стратегийг нэгтгэж, хөдөө орон нутгийн замуудад, аюулгүй байдлын арга хэмжээ авах боломжтой протоколыг боловсруулсан. Siergiejczyk et al. (2022) төмөр замын видео хяналтын системийн үйл ажиллагааны найдвартай байдлыг үйл ажиллагааны загвар ашиглан дүн шинжилгээ хийж, системд хэрэглэгдэж буй шийдлүүдийн аюулгүй байдлыг бууруулах боломжтойг тогтоосон. Ambros et al. (2019) Чехийн авто замын сүлжээнүүдэд ослыг урьдчилан таамаглах загварыг боловсруулж, хамгийн сүүлийн үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээ, сүлжээний аюулгүй байдлын зэрэглэлийг боловсруулсан. Mwanje et al. (2024) холбогдсон болон бие даасан тээврийн хэрэгслийн боломжит кибер аюулгүй байдлын халдлагыг туршилтын

өгөгдлийн багцаар судалж, итгэлцэлд суурилсан олон төрлийн кибер аюулгүй байдлын шийдлүүдийн давуу болон сул талуудыг тодорхойлжээ.

Zhang et al. (2018) Хятад-Пакистаны эдийн засгийн коридорын макро микро түвшинд нийгмийн эрсдэлийг илтгэх 8 бүлгийн 24 дэд шалгуурыг ашиглан АНР аргыг ашиглан үнэлж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны нийгмийн эрсдэлийг тодорхойлсон. Argyroudou et al. (2019) геотехникийн болон цаг уурын аюулд өртөж буй тээврийн чухал дэд бүтцийн эмзэг байдлын үнэлгээний талаар сүүлийн үеийн судалгаануудад судлагдсан байдлын тойм хийж, тээврийн хэрэгсэлд үзүүлэх нөлөөг нэгтгэн дүгнэж, нийтлэг хохирлын хэлбэрүүдийг тодорхойлсон. Love et al. (2022) томоохон хэмжээний тээврийн төслүүдийг барьж байгуулах явцад яагаад чанар муутай байдаг талаар судалгаа явуулж, чанар муутай байдлыг таслан зогсоохын тулд төр, хувийн хэвшил хамтран ажиллаж, хөрөнгийн үр ашиг, үнэ цэнийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд эрсдэлээ хуваалцах нь чухал байгааг тогтоосон. Chang et al. (2023) Хятад-Австрали далайн тээврийн замд байесын сүлжээ болон гэмтлийн модны аргыг ашиглан шингэрүүлсэн байгалийн хийн тээвэрлэлтийн үйл явцад гарах 22 эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн матрицыг ашиглан үнэлсэн.

Makarova et al. (2024) нар Арктикийн бүс нутгийн дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд байгаль орчны үзүүлэх нөлөө, эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн төрлөөс хамааран байгаль орчны эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх алгоритмыг боловсруулжээ. Lasota et al. (2025) зам тээврийн эрсдэлийг үнэлэх арга, хэрэгслийн талаарх судлагдсан байдлын шинжилгээ хийж, том оврын ачаа тээвэрлэхэд гарах эрсдэлийг тодорхойлоход эрсдэлийн матрицыг ашиглан эрсдэлийн үнэлгээний загварт ерөнхий хандлагыг санал болгожээ. Hilmola (2007) Европын төмөр замын үр ашиг, эрэлт буурах үед пүүсүүдийн дасан зохицох чадварыг үнэлж, Балтын орнууд, Эстони, Латви зэрэг улсуудын төмөр замууд ачаа тээвэрлэхэд хамгийн үр дүнтэй байгааг тодорхойлсон.

Дээрх судалгаануудад тээврийн сүлжээнд нөлөөлж буй саад бэрхшээл, уян хатан байдал, барилгын чанарын байдал, аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээнд ашиглаж буй аргазүй, шалгуур үзүүлэлт тодорхойлсон бөгөөд GREREC загвар, олон давхаргат, хөдөлгөөнд мэдрэмтгий загварчлал, сүлжээний дүн шинжилгээ, АНР арга, Байесын сүлжээ болон гэмтлийн модны арга, эрсдэлийн матриц аргуудыг ашигласан байна.

(V) Тээврийн сүлжээ, коридорын хувилбаруудын харьцуулсан үнэлгээ: Vulevic et al. (2018) Сербийн дунаве коридор дахь удирдлагын нэгжүүдийн хүртээмж, тээврийн дэд бүтцийн тэгш бус байдлыг газарзүйн мэдээллийн систем дээр суурилсан олон шалгалтын шинжилгээний загварыг боловсруулсан. Zhao et al. (2018) Хятадын 27 хотыг сонгон авч, төмөр зам, авто замын сүлжээн дэх зангилаа тус бүрийн ач холбогдлыг цогц сүлжээний онол, TOPSIS загварыг ашиглан үнэлсэн. Banick et al. (2021) Балбын алслагдсан, уулархаг Карнали мужийн хөдөө орон нутгийн зам барих хувилбаруудыг улирлын чанартай үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд олон төрлийн зардал-цаг хугацааны загвар ашиглан үнэлсэн. Lovelace (2021) тээвэр төлөвлөлтөд орон зайн шинжилгээ хийхэд шинээр гарч ирж буй нээлттэй эх хэрэглүүрүүдийн талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, 25 хэрэгсэл нь тээврийн төлөвлөлтийг дэмжих зорилгоор орон зайн шинжилгээнд зориулагдсан болохыг тогтоосон. Zhang et al. (2021) ачааны машин, нисгэгчгүй тээврийн систем (Дрон)-ийг ашиглан хүмүүнлэгийн тусламжийн сүлжээг үнэлсэн. Colling et al. (2022) Европын хамгийн том дотоод навигацийн коридор болох Рейн, Дунай мужуудад усан онгоцоор тээвэрлэх платуоны тээврийн үзэл баримтлалын хэрэгжилтийг судалж, Рейн мөрөнд усан платуоныг ашиглах нь Дунай мөрнийхөөс илүү ирээдүйтэй болохыг тогтоожээ. Tian et al. (2024) хотын төмөр замын транзит сүлжээний маршрут сонголт, загварчлалын талаар судлагдсан байдлын шинжилгээ хийж, магадлалын маршрутын сонголтын загварчлал, аяллын цагийн хэлхээнд тулгуурласан маршрутын сонголтын загварчлалыг боловсруулжээ. Ahmed et al. (2025) судлагдсан байдлын шинжилгээнд тулгуурлан хурдны замыг үнэлэх эдийн засаг, байгаль орчин,

нийгэм, зардал, үр ашиг зэрэг хүчин зүйлсийн хүрээнд 30 шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, үнэлгээ хийсэн. Moon et al. (2015) TOPSIS техникийг ашиглан БНСУ болон Европыг холбосон зургаан сонгосон тээврийн маршрутад харьцуулсан дүн шинжилгээ хийсэн. Vulevic et al. (2018) Сербийн Дунай коридорын тээврийн хүртээмжийг үнэлэхдээ урт, нягтшил, оршин суугчдын тоо, аяллын хугацаа, дундаж хурд, үйлчилгээний түвшин гэсэн шалгууруудыг ашигласан. Theocharis et al. (2018) сүүлийн 10 жилийн хугацаанд Арктик ба уламжлалт авто болон төмөр замын тээврийн маршрутын харьцуулсан шинжилгээг ном зүйн тоймд тулгуурлан хийж, маршрутын сонголтын шийдвэр гаргах хүчин зүйлсийн үзэл баримтлалын хүрээг боловсруулжээ.

Тээврийн сүлжээ, коридорын хувилбаруудын харьцуулсан үнэлгээ хийхдээ олон шалгалтын шинжилгээний загвар (Vulevic et al., 2018), TOPSIS загвар (Zhao et al., 2018; Moon et al., 2015), зардал-цаг хугацааны загвар (Banick et al., 2021), маршрутын сонголтын загварчлал (Tian et al., 2024), алхам алхмаар жингийн үнэлгээний харьцааны шинжилгээ (SWARA) арга, Аналитик сүлжээний процесс (ANP) аргууд (Ahmed et al., 2025)-ыг ашигласан байна. Судалгааны үр дүнг болон үүсгэсэн загвараа бататгахын тулд нар мэдрэмжийн шинжилгээг (Zhang et al., 2021; Vulevic et al., 2018) ашигласан байна.

Аргазүйн харьцуулсан шинжилгээ: АНУ-ын орон нутгийн тээврийн төлөвлөлтийн байгууллагууд тээвэр төлөвлөлтийн үйл ажиллагааг дэмжихийн тулд газарзүйн мэдээллийн системийн (GIS) программ хангамжийг ашиглаж эхэлснээс хойш 1990-ээд оноос хойш газарзүйн шинжилгээний хэрэгслүүдийг тээврийн төлөвлөлтөд ашиглаж эхэлсэн (Anderson L, 1991).

Гарал үүслийн болон очих газрын загварчлал, маршрутын үнэлгээ, орон зайн сүлжээний шинжилгээ зэрэг газарзүйн аргууд нь ном зохиолд чухал байр суурь эзэлдэг бөгөөд энэ нь тээврийн төлөвлөлтийн олон арга хэмжээний талаар нотлох баримт болдог (Jäppinen et al., 2013; Larsen et al., 2013; Tribby, Zandbergen, 2012).

Энэхүү судалгаанд ашигласан өгүүлүүдэд олон арга аргачлалыг ашиглаж байгаа бөгөөд аналитик математикийн болон эмпирик статистикийн аргуудыг гол төлөв ашигласан нь тогтоогдсон.

Эдгээр аргуудын судалгааны агуулга, зорилгоос хамааран бага зэргийн ялгаатай байна. Тухайлбал тээврийн сүлжээний үр ашгийг үнэлэхэд өгөгдлийн бүрхүүлийн шинжилгээ, гүйцэтгэлийг үнэлэхэд гүйцэтгэлийн гол шалгуур болон хүчин зүйлийн кластерын шинжилгээ, өгөгдлийн бүрхүүлийн шинжилгээний (DEA) арга, байгаль нийгэм эдийн засгийн нөлөөллийг үнэлэхэд олон шалгуурт шийдвэр гаргалтын арга, олон шалгуурын шинжилгээний арга (MCA), асуулга судалгааны арга, эрсдэлийг үнэлэхэд GREREC загвар, олон давхаргат, хөдөлгөөнд мэдрэмтгий загварчлал, сүлжээний дүн шинжилгээ, АНП арга, байесын сүлжээ, гэмтлийн модны арга, эрсдэлийн матриц, сүлжээний харьцуулсан үнэлгээнд хувьд үнэлэхэд олон шалгалтын шинжилгээний загвар, TOPSIS загвар, зардал-цаг хугацааны загвар, маршрутын сонголтын загварчлал, MCA, түүнтэй төстэй аргууд, Аналитик сүлжээний процесс (ANP) аргуудыг гол төлөв ашиглаж байна. Дараах хүснэгт 1-т хянагдсан өгүүлүүдэд ашигласан гол аргуудыг үзүүлэв.

Хүснэгт 1. Тээврийн салбарт түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний аргууд, тэдгээрийн давуу болон сул тал

	Арга	Давуу тал	Сул тал	Эх сурвалж
Эмпирик статистик	Хүчин зүйлийн дүн шинжилгээний арга	Илүүдэл мэдээллийг багасгах; үзүүлэлтүүдийн хамаарлыг бууруулах; хүчин зүйлд үзүүлэх нөлөөллийн зэрэглэлийг тооцоолох.	Мэдээллийн үнэн зөв байх шаардлагатай; Мэдээллийн тоо хэмжээ, чанар нь тодорхой шаардлагыг хангаж байх ёстой; Гаргаж авсан үр дүн нь ойлгомжтой биш байж магадгүй.	(Lim et al., 2017)
	Кластерын дүн шинжилгээний арга	Ангиллын тоог урьдчилан тодорхойлохгүйгээр ангиллын оновчтой тоог автоматаар тодорхойлох; тодорхойлсон үр дүнд тулгуурлан нийтлэг болон ялгааг тодорхойлох.	Түүврийн өгөгдлийн анхны утгыг мэдэрдэг; Зайд суурилсан хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал болон жинд мэдрэмтгий.	(Wang, Pham, 2020; Talukdar et al., 2023)
	Grey-н корреляцийн шинжилгээ	Мэдээлэл багатай үед ашиглах боломжтой; математик боловсруулалт нь энгийн; бүх төрлийн өгөгдлийг ашиглаж чаддаг; шийдвэр гаргалтад үр дүнтэй ашиглагддаг	Субъектив байдал орж болзошгүй; хамаарлын шалтгааныг илрүүлэхгүй; Цаг хугацааны хамаарлыг тооцдоггүй (анхны хувилбар); Нормчлолд мэдрэг байдал;	(Huang et al., 2018)
Аналитик математик	Үүлэн загвар	Fuzziness ба Randomness-ийг нэгтгэсэн; Мэдлэгийг тоон болон чанарын байдлаар илэрхийлдэг; Олон шалгуурт шийдвэр гаргалтад тохиромжтой	Ойлгоход төвөгтэй, онолын суурь шаарддаг; Тооцооллын нарийн төвөгтэй байдал; Загвар тохируулахад эмзэг; Тодорхой нөхцөлд л бусдаас давуу	(Hu et al., 2022)
	Тодорхой бус элементийн арга	Үзүүлэлтийн хэмжүүрийг харьяалал болгон хувиргах; үл нийцэх асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх.	Жинг тодорхойлоход АНР ашиглах нь илүү субъектив шинж чанартай байдаг.	(Lv et al., 2020)
	Энтропийн жин- TOPSIS	Хэрэглэх чадвар өндөр; Ойлгомжтой логиктой; Шалгуурын нэгжээс хамаарахгүй; Шийдвэр гаргалтын хурд өндөр; Олон шалгуурт тохиромжтой	Жин (weight) хэт их нөлөөлдөг; Харьцангуй хамаарлаар үнэлдэг; Төгс ба муу хувилбарын хийсвэр байдал; Чанарын үзүүлэлтэд хязгаарлагдмал	(Huang et al., 2018; Moon et al., 2015)
	AHP	Тодорхой бус байдлыг бүрэн харгалзан чанарын тодорхойлолт ба тоон шинжилгээг хослуулсан нь үнэлгээг илүү өргөн хүрээтэй болгодог.	Жинг тодорхойлох нь маш субъектив юм.	(Xiaoning, Xiudan, 2010)
